# ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
# 2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |

**Агуулга**

1.Төрийн аудитын санал, дүгнэлт ....3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан....4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ....4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ....5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан....7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ....9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ....10
3.Аудитын тайлан....12
3.1. Ерөнхий зүйл....12
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй ....12
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт ....13
3.4. Материаллаг байдал ....13
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд ....13
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт ....14
3.7. Шилэн дансны мэдээлэл ....14
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ....14
3.9. Аудитын илрүүлэлт....15
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил ....15
Аудитын зөвлөмж....15
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд ....15
4. Менежментийн захидал....15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт ....16

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2021.02.25 № 07/513
танай _____-ны № _____-т

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА Л.НОМИН ТАНАА

Аудитын санал дүгнэлт

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эрүүл мэндийн даатгалын зөвлөлийн ажлын албаны 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Эрүүл мэндийн даатгалын зөвлөлийн ажлын албаны 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Бусад мэдээлэл**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн хурлаар 2020 онд хэлэлцүүлэх асуудлыг төлөвлөгөөний дагуу цаг хугацаанд нь бүрэн хэлэлцүүлж, дүрэм, журмыг баталсан байна.

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 15 зорилтын хүрээнд 27 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 95.9 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

001050978

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой. Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **2,511,950.00** | **4,799,231.00** |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **2,511,950.00** | **4,799,231.00** |
| **354** | **Хангамжийн материал** | **2,511,950.00** | **4,799,231.00** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 471,668.00 | 992,646.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 40,796.00 | 40,796.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 200,000.00 | 1,700,000.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 1,799,486.00 | 2,065,789.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **10,742,352.58** | **31,662,372.16** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **10,742,352.58** | **31,662,372.16** |
| **392** | **Биет хөрөнгө** | **10,313,352.59** | **29,965,372.16** |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 13,490,914.00 | 37,699,604.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -3,834,701.41 | -9,246,911.84 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 679,800.00 | 1,869,600.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | | |
| **393** | **Биет бус хөрөнгө** | **428,999.99** | **1,697,000.00** |
| 39301 | Програм хангамж | 847,000.00 | 2,391,500.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -418,000.01 | -694,500.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **13,254,302.58** | **36,461,603.16** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **13,254,302.58** | **36,461,603.16** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **13,254,302.58** | **36,461,603.16** |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | **13,254,302.58** | **36,461,603.16** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 13,254,302.58 | 13,254,302.58 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 23,207,300.58 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **13,254,302.58** | **36,461,603.16** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **313,317,100.00** | **380,915,400.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **313,317,100.00** | **380,915,400.00** |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | **313,317,100.00** | **380,915,400.00** |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 313,317,100.00 | 380,915,400.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **309,164,385.61** | **357,708,099.42** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **309,164,385.61** | **357,708,099.42** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **221,899,515.05** | **215,833,403.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **164,274,665.55** | **158,749,234.37** |
| 210101 | Үндсэн цалин | - | 115,145,442.13 |
| 210102 | Нэмэгдэл | 138,277,820.70 | 19,708,981.39 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 4,912,702.85 | 7,017,000.00 |
| 210104 | Урамшуулал | 21,084,142.00 | 16,877,810.85 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **25,176,296.74** | **19,332,141.21** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 17,563,287.74 | 13,207,022.45 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,963,749.00 | 1,541,789.76 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,605,443.00 | 1,336,120.61 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 358,083.00 | 286,867.18 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,685,734.00 | 2,960,341.21 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **8,597,800.00** | **18,506,135.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 2,610,054.00 | 5,229,627.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,465,000.00 | 7,000,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,522,746.00 | 6,276,508.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **534,997.00** | **500,497.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 534,997.00 | 500,497.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **8,529,440.00** | **1,603,300.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 8,529,440.00 | 1,603,300.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **2,666,200.00** | **4,435,000.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 838,300.00 | 4,375,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,827,900.00 | 60,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **12,120,115.76** | **12,707,095.42** |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 8,328,081.00 | 5,529,125.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 3,792,034.76 | 7,177,970.42 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **87,264,870.56** | **141,874,696.42** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **2,500,000.00** | **300,000.00** |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 2,500,000.00 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | - | 300,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **3,832,485.85** | **-** |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 3,832,485.85 | - |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **80,932,384.71** | **141,574,696.42** |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 80,932,384.71 | 141,574,696.42 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **4,152,714.39** | **23,207,300.58** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **4,152,714.39** | **23,207,300.58** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **139,766,200.00** | **380,915,400.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **139,766,200.00** | **380,915,400.00** |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | **139,766,200.00** | **380,915,400.00** |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 139,766,200.00 | 380,915,400.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **83,093,333.47** | **352,817,410.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **83,093,333.47** | **352,817,410.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **81,082,767.62** | **210,942,713.58** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **60,952,070.62** | **158,749,234.37** |
| 210101 | Үндсэн цалин | - | 115,145,442.13 |
| 210102 | Нэмэгдэл | 57,969,367.77 | 19,708,981.39 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 2,982,702.85 | 7,017,000.00 |
| 210104 | Урамшуулал | - | 16,877,810.85 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **12,457,800.00** | **19,332,141.21** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 8,471,400.00 | 13,207,022.45 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 996,600.00 | 1,541,789.76 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 797,400.00 | 1,336,120.61 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 199,200.00 | 286,867.18 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 1,993,200.00 | 2,960,341.21 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **3,136,102.00** | **21,195,413.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 1,037,355.00 | 5,959,400.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 800,000.00 | 8,500,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,298,747.00 | 6,736,013.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **135,997.00** | **533,500.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 135,997.00 | 533,500.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **168,000.00** | **1,603,300.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 168,000.00 | 1,603,300.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **2,095,220.00** | **4,000,000.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,039,800.00 | 4,000,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 695,420.00 | - |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 360,000.00 | - |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **2,137,578.00** | **5,529,125.00** |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,137,578.00 | 5,529,125.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **2,010,565.85** | **141,874,696.42** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **-** | **300,000.00** |

| | | | |
|---|---|---|---|
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | - | 300,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **2,010,565.85** | **-** |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 2,010,565.85 | - |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **-** | **141,574,696.42** |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 141,574,696.42 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **56,672,866.53** | **28,097,990.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **3,695,000.00** | **28,097,990.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **3,695,000.00** | **28,097,990.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **3,695,000.00** | **28,097,990.00** |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 3,695,000.00 | 28,097,990.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(3,695,000.00)** | **(28,097,990.00)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | **52,977,866.53** | **-** |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **2,010,565.85** | **-** |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **54,988,432.38** | **-** |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| **C01** | **2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **-** | **-** | **-** | **-** |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| **C03** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **-** | **-** | **-** | **-** |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | - | - | - | - |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | - | - | - | - |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | - | 9,101,588.19 | 9,101,588.19 |
| **D01** | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **-** | **-** | **13,254,302.58** | **13,254,302.58** |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| **D03** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **-** | **-** | **13,254,302.58** | **13,254,302.58** |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | - | - | - |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | - | - | - | - |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | - | - | - | - |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | 23,207,300.58 | 23,207,300.58 |
| **D09** | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **-** | **-** | **36,461,603.16** | **36,461,603.16** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **380,915,400.00** | **239,340,703.58** | **141,574,696.42** | **62.8** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **380,915,400.00** | **239,340,703.58** | **141,574,696.42** | **62.8** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **370,915,400.00** | **239,040,703.58** | **131,874,696.42** | **64.4** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **237,887,900.00** | **158,749,234.37** | **79,138,665.63** | **66.7** |
| 210101 | Үндсэн цалин | 142,765,200.00 | 115,145,442.13 | 27,619,757.87 | 80.7 |
| 210102 | Нэмэгдэл | 54,524,700.00 | 19,708,981.39 | 34,815,718.61 | 36.1 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 17,160,000.00 | 7,017,000.00 | 10,143,000.00 | 40.9 |
| 210104 | Урамшуулал | 23,438,000.00 | 16,877,810.85 | 6,560,189.15 | 72.0 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **32,115,000.00** | **19,332,141.21** | **12,782,858.79** | **60.2** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 22,599,400.00 | 13,207,022.45 | 9,392,377.55 | 58.4 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,378,900.00 | 1,541,789.76 | 837,110.24 | 64.8 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,903,100.00 | 1,336,120.61 | 566,979.39 | 70.2 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 475,800.00 | 286,867.18 | 188,932.82 | 60.3 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,757,800.00 | 2,960,341.21 | 1,797,458.79 | 62.2 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **25,000,000.00** | **-** | **25,000,000.00** | **0.0** |
| 210304 | Байрны түрээс | 25,000,000.00 | - | 25,000,000.00 | 0.0 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **25,202,200.00** | **21,633,403.00** | **3,568,797.00** | **85.8** |
| 210401 | Бичиг хэрэг | 7,607,100.00 | 6,267,400.00 | 1,339,700.00 | 82.4 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 8,500,000.00 | 8,500,000.00 | - | 100.0 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 9,095,100.00 | 6,866,003.00 | 2,229,097.00 | 75.5 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **27,000,000.00** | **25,802,000.00** | **1,198,000.00** | **95.6** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 27,000,000.00 | 25,802,000.00 | 1,198,000.00 | 95.6 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **5,534,400.00** | **1,603,300.00** | **3,931,100.00** | **29.0** |
| 210702 | Дотоод албан томилолт | 5,534,400.00 | 1,603,300.00 | 3,931,100.00 | 29.0 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **11,770,900.00** | **6,391,500.00** | **5,379,400.00** | **54.3** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 8,000,000.00 | 4,000,000.00 | 4,000,000.00 | 50.0 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 3,410,900.00 | 2,391,500.00 | 1,019,400.00 | 70.1 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 360,000.00 | - | 360,000.00 | |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **6,405,000.00** | **5,529,125.00** | **875,875.00** | **86.3** |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 6,405,000.00 | 5,529,125.00 | 875,875.00 | 86.3 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **10,000,000.00** | **300,000.00** | **9,700,000.00** | **3.0** |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 10,000,000.00 | 300,000.00 | 9,700,000.00 | 3.0 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **-** | **380,915,400.00** | **(380,915,400.00)** | |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | | | - | |
| **1340** | **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **-** | **380,915,400.00** | **(380,915,400.00)** | |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | - | 380,915,400.00 | (380,915,400.00) | |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | **1** | **1** | | **100.0** |
| 610001 | Төсвийн байгууллага | 1 | 1 | | 100.0 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | **21** | **17** | **4** | **81.0** |
| 620001 | Удирдах ажилтан | 3 | 3 | | 100.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 18 | 14 | 4 | 77.8 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **21** | **17** | **4** | **81.0** |
| 650003 | Ажлын албаны албан хаагч (АА) | 18 | 16 | 2 | 88.9 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 3 | 1 | 2 | 33.3 |

## 3.Аудитын тайлан

### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Эрүүл мэндийн даатгалын зөвлөлийн ажлын албаны 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн ажлын албаны дарга Л.Номин танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд дотоод аудитын талаар өгсөн зөвлөмжийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-наас 2021 оны 02 дугаар сарын 25–ны хооронд анхан шатны хяналтыг Үндэсний аудитын газрын Хоёрдугаар газрын менежер Г.Гүнжидмаа хэрэгжүүлж, Ахлах аудитор Р.Цолмон аудитор Г.Мөнхчимэг хариуцаж гүйцэтгэв.

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн ажлын албаны 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 20-ний өдрийн 12 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Эрүүл мэндийн даатгалын зөвлөлийн ажлын албаны үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Эрүүл мэндийн даатгалын үндэсний сангийн болон эрүүл мэндийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны зардлын төсвийн төсөл, төсөөлөл, төсвийн хүрээний мэдэгдлийг актуар тооцоололд үндэслэн боловсруулах, батлагдсан төсвийн нарийвчилсан хуваарийг батлах, гүйцэтгэлд нь хяналт тавих;
- Эрүүл мэндийн даатгалын сангийн болон эрүүл мэндийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны тайланг хэлэлцэх, үйл ажиллагааны болон удирдлагын зардлыг хянах, үнэлэлт, дүгнэлт өгөх;
- Эрүүл мэндийн даатгалтай холбогдсон асуудлаар ирүүлсэн өргөдөл гомдлыг шийдвэрлэх;
- Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багцад орох тусламж, үйлчилгээний жагсаалтыг эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн батлах;
- Даатгуулагчид үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлын Эрүүл мэндийн даатгалын сангаас төлөх төлбөрийн дээд хязгаар, энэ хуулийн 11.2-т заасан даатгуулагчийн төлөх төлбөрийн хэмжээг нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн тухай бүр тогтоох;
- Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт олгох зайлшгүй шаардлагатай эмийн нэр төрөл, үнийн дээд хязгаар, хөнгөлөх хэмжээг нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн тогтоох;
- Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагыг сонгон шалгаруулах журмыг нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн батлах болон Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд заасан чиг үүрэг.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна.

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Бид санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

### 3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлын 309,164.4 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 6,183.3 мянган төгрөгөөр тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

### 3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн ажлын албаны 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 23,207.3 мянган төгрөгөөр буюу 232.1 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс үндсэн хөрөнгийн дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 0 | 0 | 0 |
| Авлага | 0 | 0 | 0 |
| Урьдчилгаа | 0 | 0 | 0 |
| Бараа материал | 2,511.9 | 4,799.2 | 2,287.3 |
| Үндсэн хөрөнгө | 10,742.3 | 31,662.3 | 21,308.9 |
| **Нийт хөрөнгө** | **13,254.2** | **36,461.5** | **23,596.2** |
| Өр төлбөр | 0 | 0 | 0 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 13,254.3 | 36,461.6 | 23,207.3 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **13,254.3** | **36,461.6** | **23,207.3** |

Бараа материалын дансны үлдэгдэл 4,799.2 мянган төгрөг болж 2,287.3 мянган төгрөгөөр өссөн нь хангамжийн материал 2,106,5 мянган төгрөг, бичиг хэргийн материал 992.6 мянган төгрөг, шатахууны талон 1,700.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь нөлөөлжээ.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 31,662.3 мянган төгрөг болж, 21,308.9 мянган төгрөгөөр өссөн байна. Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл өссөн эд хогшил, урсгал засварын зардлын төсвөөс 24,078.7 мянган төгрөгийн компьютер, принтер, тоног төхөөрөмж, 1,189.8 мянган төгрөгийн тавилга хэрэгсэл, мэдээлэл технологийн зардлын төсвөөс 2,391.5 мянган төгрөгийн программ хангамж тус тус бэлтгэснээс шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 36,461.6 мянган төгрөг болж 23,207.7 мянган төгрөгөөр өссөн байна.

### 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

**Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 418,867.8 мянган төгрөгөөр, тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 37,952.4 мянган төгрөгөөр бууруулж 380,915.4 мянган төгрөгөөр баталсан байна.

Дээд шатны байгууллагад хүргүүлсэн төсвийн төслийн саналаас 380,915.4 мянган төгрөгийг бууруулж баталсан, мөн төсвийн гүйцэтгэлээр тайлант хугацаанд 141,574.7 мянган төгрөгийг даатгалын санд буцаан төвлөрүүлсэн нь төсвийн төлөвлөлт бодитой боловсруулаагүй байгааг харуулж байна.

**Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 19 арга хэмжээг санхүүжүүлэхээр 380,915.4 мянган төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр үйл ажиллагаанд 239,340.7 мянган төгрөгийг зарцуулж 141,574.7 мянган төгрөгийг даатгалын санд буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 239,340.7 мянган төгрөг буюу 62.8 хувьтай байгаа нь цалин, хөлс, нийгмийн даатгалын даатгалын шимтгэлийн зардлыг 91,921.5 мянган төгрөгөөр, байрны түрээсийн зардлыг 25,000.0 мянган төгрөгөөр, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлыг 9,700.0 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

### 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 121 мэдээллээс хугацаандаа оруулсан 53 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл, хугацаа хоцроосон 24 мэдээлэл, 44 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна.

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлагыг биелүүлсэн байна. Аудитаар өгсөн 4,156.7 мянган төгрөгийн зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

*Хүснэгт 3* Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилт

/мянган төгрөг/

| № | Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | |
|---|---|---|---|---|---|
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Зөвлөмж | 4 | 4,156.7 | 4 | 4,156.7 |
| 2 | Албан шаардлага | 1 | - | 1 | - |
| | **Нийт дүн** | **5** | **4,156.7** | **5** | **4,156.7** |

### 3.9. Аудитын илрүүлэлт

**Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил**

Аудитаар дараах албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 53 мэдээллийг хугацаанд нь 24 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 44 мэдээллийг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.4.5 -д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.4-т "төрөөс үзүүлж байгаа аливаа ажил, үйлчилгээ, хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, тэдгээрийн хүрээнд худалдан авч байгаа бараа, ажил, үйлчилгээнд олон нийт хяналт тавих боломжоор хангах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулж, ил тод байдлыг хангаж ажиллах албан шаардлага өгөх.

**Аудитын зөвлөмж**

Аудитаар 1 зөрчилд зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

### 3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн ажлын албаны 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитаар гүйцээж шалгаагүй горим сорил болон анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

## 4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

***Дотоод хяналттай холбоотой асуудал***

1.1. Илрүүлэлт: Тайлант онд Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн ажлын албанд санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийгдээгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10-д "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" гэсэн заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

1.2. Эрсдэл: Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналт сул байх.

1.3. Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10-д “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх”, зөрчлийг давтан гаргахгүй байх.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

| Огноо: | Аудитын нэр: | | Аудитын код: |
|---|---|---|---|
| 2021.02.25 | | ***Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн ажлын албаны 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит*** | **САГ-2021/158/СТА-ТШЗ** |
| Шалгагдсан байгууллагын нэр: | | ***Эрүүл мэндийн даатгалын зөвлөл*** | Мянган төгрөг |

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгуул-лагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|---|---|---|---|
| | | | Нэр | Албан тушаал | Овог нэр |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 53 мэдээллийг хугацаанд нь 24 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 44 мэдээллийг байршуулаагүй байна. | - | Албан шаардлага | Ажлын албаны дарга, Нягтлан бодогч | Л.Номин, Д.Сувдаа |
| 2 | Тайлант онд Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн ажлын албанд санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийгдээгүй байна. | - | Зөвлөмж | Ажлын албаны дарга, Нягтлан бодогч | Л.Номин, Д.Сувдаа |
| **ДҮН** | | **-** | | | |

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
**АЛБАН ШААРДЛАГА**

2021 оны 02 дугаар сарын 25 № 65/А0170074
СЯГ-2021/158/СТА-ТЦЗ
Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 53 мэдээллийг хугацаанд нь 24 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 44 мэдээллийг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.4.5 -д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.4-т "төрөөс үзүүлж байгаа аливаа ажил, үйлчилгээ, хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, тэдгээрийн хүрээнд худалдан авч байгаа бараа, ажил, үйлчилгээнд олон нийт хяналт тавих боломжоор хангах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулж, ил тод байдлыг хангаж, биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн ажлын албаны дарга Л.Номин, нягтлан бодогч Д.Сувдаа нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТОР Г.МӨНХЧИМЭГ

ТЭМДЭГЛЭЛ